

АЛДАГДСАН БОЛОМЖ (МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ)

Н. Болдбаатар

Энэ дэлхийн эртний угсаатнуудын нэг болох Монголчууд бид 2200 жилийн өмнөөс өөрийн төрт улсаа байгуулж ирсэн, мандан бадарч ертөнцийн талыг эзлэн хүчирхэгжиж явсан, буурч доройтон бусдын эрхэнд орж ч байсан баялаг, баатарлаг боловч эмгэнэлт түүхтэй их үндэстэн билээ. Түүхийн урт ээдрээтэй замыг туулахдаа Монгол угсаатан хамтдаа газар нутаг, байгалийн баялаг, мал сүрэг, хоол, хүнс, эд агуурс, сэтгэлийн тэнхээ, оюуны чадавхи, соёл, цэрэг, зэвсгийн хүчин чадал, эх оронч үзэл, эрз ориг зэргээр бусдаас дутаж байгаагүй юм. Харин ганцхан зүйлээрээ л хөрш улс, гүрнүүдээс дутаж байлаа. Энэ нь хүний тоо, хүн амын хэмжээ байв. Энэ дутагдал дэлхийн хамгийн олон хүнтэй хятад улстай олон мянган жилээр айл хөрш оршиж ирснээс үүдэн улам ч хурцаар мэдрэгдэж байсан юм. Биднийг хүрээлэн байсан бусад үндэстэн, угсаатнууд Монголын энэ сул талыг сайн мэдэж, хүний олноороо давамгайлах, манай хүн амыг өсгөхгүй байх, түүгээр ч барахгүй хорогдуулахын тулд бүхнийг хийж, тэр ч байтугай боломж олдвол эр, эм, хөгшид, хүүхэд гэж ялгахгүйгээр хүйс тэмтрэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ. Үүний нэг жишээ нь: Манж гүрнээс 1757 онд Монголын тусгаар тогтнолын эцсийн голомт болж байсан Зүүнгарын улсыг эзлэснийхээ дараа Ойрадын баатарлаг ард түмнийг эр эм, хөгшид гэж ялгалгүй үндсээр нь

¹ Н. Болдбаатар. Хүн судлалын үндэсний Төвийн эрдэм шинжилгээний ажилтан

хүйс тэмтрэх бодлого явуулсан явдал юм. Энэхүү харгис бодлогын улмаас Зүүнгарын 600 мянган Монголчуудаас (зарим мэдээгээр сая гэдэг) тун цөөн үлдэж, өргөн уудам, баян тансаг нутаг орон нь эзгүйрсэн түүхтэй. Мөн түүнчлэн манж гүрнээс Монголд бурханы шашныг дэлгэрүүлэхийг бүх талаар дэмжих, их хүч чармайлт тавьж байсан нь цаанаа Монголчуудын тоог цөөлөх, оюун санааг нь мохоон эзэмдэх, эрэлхэг дайчин чанарыг алдагдуулах гэсэн далдын хар санаатай байсан байна. Үүний хамт хөрш гүрнүүдээс Монголчуудын тоог цөөлөх, болж өгвөл үндэстний хувьд үгүй хийх зорилгын үүднээс тархаан бутаргах, ястнуудын хооронд эвдрэлцүүлэн, дайтуулан салгах, уусгах бодлогыг олон зуун жилийн турш дэс дараатайгаар, шургуу авч хэрэгжүүлж байсан нь энэ зуунд ч мөн үргэлжлэн ирснийг бид мэднэ.

Аливаа улсын хүн ам нь байгаль нийгмийн олон хүчин зүйлийн үйлчлэлийг өөртөө агуулсан маш нарийн нийлмэл цогцос болно. Ийм ч учраас хүн амын тоо байнга үргэлж өсөөд байхгүй нийгэм-эдийн засаг, байгалийн тохиромжтой нөхцөл бүрэлдэхэд өсөж, зарим үед бүр үерэлт маягаар өсөж байснаа нэг үед тогтворжиж, зогсонги байдалд орж, түүгээр ч барахгүй хорогдох, бүр устах байдалд ч ордог. Тухайлбал: Хятадын хүн амын тоо XI—XV зуунд тогтмол ойролцоогоор 80 сая орчимд хэлбэлзэж байсан бол XVI зуунаас нэлээд өсөж 140 сая болсноо XVIII зуунаас өсөлт нь түргэсэж XX зууны эх гэхэд 400 саяд хүрсэн юм. Мөн Орос улсын хүн амын өсөлт XVII зуунаас түргэсэж зөвхөн XIX зуунд 3 дахин олширсон билээ. Тэгвэл Англи улсын хүн амын тоо XVII зуун хүртэл бараг зогсонги 3—4 сая байснаа огцом өсөж хэдийгээр далайн чанадад олон тооны хүн шилжин нүүдэллэсэн боловч зөвхөн 1800—1900 оны хооронд 9 саяас 32 сая болсноо нэмэгдсэн байна. Иймэрхүү жишээг бусад олон оронд ч харж болох байна. Манай Монгол туургатантай адилаар нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан цөөхөн хүн амтай Араб, Түрэг туургатнуудын хүн ам ч гэсэн хүн амзүйн тохиромжтой нөхцөлөө алдалгүй эрс өсөж одоо 100—250 саяд хүрчээ.

Монгол туургатны хувьд хүн амын тооны хувьд өсөх, түүгээр ч барахгүй эрс өсөж болох боломж тохиолдож байсныг үгүйсгэх аргагүй юм. Гэвч гадаад, дотоодын олон хүчин зүйлүүдийн үйлчлэлийн нөлөөгөөр XIII зуунаас бусад зуунд энэ боломжоо бодит байдал болгож цөөхөн хүн амынхаа тоог дорвитой өсгөж чадаагүйгээр барахгүй зарим үед тооныхоо хувьд ч цөөрч хорогдож ирсэн гунигт түүхтэй. Тухайлбал: 1800—1900 онд бүх дэлхийн хүн ам 905 саяас 1630 сая болж 60 шахам хувиар, үүний дотор Европын хүн ам 2 дахин, Азийн хүн ам 50 гаруй хувиар өссөн байхад, Монголын хүн ам хорогдсон байна.²

Монголын хүн амын тоо энэ зуунаас өмнөх үед чухам хэд байсан тухай нарийн тодорхой мэдээ байхгүй юм. Энэ нь хэдийгээр Монгол улсад урьд өмнө хүн амын тооллого, бүртгэлийг цэргийн тоог баримжаалах, албан татварыг оноох, хошуудын хил хязгаарыг тогтоох зэрэг зорилгоор тогтмол явуулж ирсэн боловч угаасаа хүн ам цөөн тул түүнийгээ чандлан нууцалж байсантай холбоотой билээ. Хэдий ийм боловч түүхийн төрөл бүрийн эх сурвалжаас үзвэл одоогийн Монгол улсын нутаг дэвсгэрийн хүн амын тоо 700 мяага орчимд нэлээд хэдэн зууны туршид хадгалагдаж ирсэн гэж үзэхэд төдий л хилсдэхгүй болов уу? хэрвээ бид энэ боломжийг алдалгүй ашиглаж цөөхөн хүн амаа өсгөж чадсан бол энэ зууны эх гэхэд доод тал нь 2 сая хүнтэй байх бүрэн бололцоотой байлаа. Гэвч харамсалтай нь

бид түүхэн энэ боломжийг эргэлтгүйгээр алдаж ХХ зууныг дөнгөж 500 мянгахан Монголчуудтай угтлаа.

ХХ зуун Монголчуудын хувьд их найдварын зуун байсан төдийгүй үнэнхүү хөгжил цэцэглэлтийн зуун ч болох сайхан боломжоор эхэлсэн юм. Сүүлийн 200 жилийн турш энэ дэлхийн хамгийн хоцрогдсон эзэнт улсын зах хязгаар болж байсан Монгол оронд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн улам бүр хүч аван өрнөсний үр дүнд 1911 онд Монгол улс Манж гүрний олон угсаатны дотроос ганцаархнаа туурга тусгаар улс болж улсаа сэргээн байгуулсан билээ. Энэхүү түүхт үйл явдлын зүй ёсны үргэлжлэл болсон 1921 оны ардын хувьсгалаар манай орны эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл шинэ үе шатанд орсон юм. Гэвч тухайн үеийн олон улсын байдал, хүчний харьцаа зэрэг гадаад хүчин зүйл түүнээс улбаалсан дотоод учир шалтгаанаас хамаарч Монгол улс жинхэнэ ёсоор сэргэн мандаж, үнэнхүү цэцэглэн хөгжих түүхэн боломжоо бүрэн дүүрэн ашиглаж бодит байдал болгож чадаагүй юм. Энэ нөхцөл байдал нь Монголын хүн амын өсөлтөд ч мөн нөлөөлсөн юм.

Олон зуун жилийн харийн ноёрхлын дараа тусгаар тогтнолоо олж, эрх чөлөөтэй аж төрөхийн үүдийг нээж, нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх боломж олдсон нь олон зуун жил зогсонги түүгээр ч барахгүй хорогдох хандлагатай байсан Монгол улсын хүн амын тоо түргэн хурдацтай өсөх түүгээр ч барахгүй эрс өсөх түүхэн нэг боломжийг төрүүлсэн болно. Гэвч энэ сайхан бололцоо боломжийг бид мөн л алдаж хүн амаа төдий л олшруулж чадсангүй.

Монгол улсын тухайн үеийн гадаад дотоод нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн бодит, бодит бус олон шалтгаанаас хамаарч манай орны хүн амын тооны өсөлт 1950-иад он хүртэл үнэн хэрэг дээрээ зогсонги байдалтай байлаа. Тухайлбал: 1918 оноос 1950 оныг хүртлэх 30 гаруй жилд тус улсын хүн ам 648,1 мянгаас 772,4 мянга болж дөнгөж 124,3 мянга буюу 19,2 хувиар өсжээ. Гэтэл энэ хугацаанд Азийн хөрш бусад орны хүн амын тоо ихээхэн өндөр хурдацтайгаар өссөн билээ.

Хүснэгт 1.

Азийн зарим орны хүн амын тооны өсөлт
1920—1950 онд³ (сая. хүнээр)

	1920	1950	өсөлт
Хятад	436	555,3	127,4
Энэтхэг	250,5	359,3	143,4
Япон	55,4	82,9	149,6
Солонгос	16,9	27,3	161,5
Афганистан	6,4	12,0	187,5
Балба	5,6	7,9	141,1
Пакистан	54,0	75,0	138,9
Бирм	13,2	18,5	140,2
Индонез	52,3	76,7	146,7
Тайланд	9,5	19,2	202,1
Филиппин	13,1*	20,5	150,7
Турк	13,6**	20,9	153,6
Монгол (мян. хүн)	648,1	772,4	119,2

* — 1930 он

** — 1927 он

Хүснэгтээс үзвэл 1920—1950 онд Хятадын хүн ам 30 шахам хувиар, Японых 50 хувиар, Солонгосынх 60 хувиар, Энэтхэгийнх 43 хувиар өссөн бөгөөд Баруун болон Зүүн өмнөд Азийн орнуудын хүн амын тоо буурч их хэмжээгээр өссөн байна. Ийнхүү Зүүн, зүүн хойт Азийн орнуудын хүн амын тооны өсөлт харьцангуй удаан байсан нь Япон, Хятад, Солонгос улс энэ хугацаанд олон жилээр дайн байлдааны байдалтай байсны уршиг юм. Үүнд ялангуяа бараг энэ бүх хугацааны туршид явагдаж байсан Хятадын дотоодын иргэний дайн, 1931 оноос эхэлсэн Японы түрмгийлэгчдийн эсрэг хийсэн дайн, дэлхийн 2-р дайн, Солонгос, Зүүн өмнөт Азийн орнуудад явагдсан эсэргүүцлийн хөдөлгөөнүүд зэрэг нь байлдаж буй хоёр талд хоёуланд нь ихээхэн хэмжээний хүн хүчний хохирлыг учруулж, хүн амын нь тооны өсөлтөд зохисгүй нөлөөг үзүүлсэн билээ. Тухайлбал: дэлхийн 2-р дайнд Япон улс 2,4 сая хүнээ, Хятад улс 10 сая хүнээ тус тус алдсан байна.⁴ Хэдий ийм боловч хүн амын төрөлтийн төвшин харьцангуй өндөр байснаас дээрх орнууд дайны хохирлоо богино хугацаанд нөхөн сэргээж, хүн амынхаа тоог түргэн өсгөж чадсан юм. Энэ хугацаанд дайнд бараг нэрвэгдээгүй Баруун ба Зүүн өмнөд Азийн орнуудад хүн амын өсөлтийн хурдац их өндөр байлаа. Үүнд: 1920—1950 онд Тайландын хүн ам 2 илүү дахин, Афганистанын хүн ам 1,9 дахин тус тус өссөн бөгөөд Туркийн хүн ам зөвхөн 1927—1950 онд 1,5 дахин, Филиппиний хүн ам 1930—1950 онд мөн 1,5 дахин тус тус өссөн байна.

Энэ зууны эхний хагаст дэлхийн хамгийн хүн ам олонтой тив болох Азийн хүн амын тооны өсөлт ихээхэн өндөр байсан боловч бусад тивийн хүн амын өсөлттэй харьцуулж үзвэл дайнд хамгийн их хохирол үзсэн Европ тивээс өндөр бусад тивээс доогуур байсан юм.

Хүснэгт 2.

Дэлхийн хүн амын өсөлт
(1920—1950) онуудад⁵ (сая. хүнээр)

№	1920	1950	Өсөлт 1920—1950
1. Европ	325	392	120,6
2. Ази	1023	1355	132,5
3. Америк	206	328	159,2
4. Африк	143	217	151,7
5. Австрали	8,5	12,6	148,2
6. Хуучин ЗХУ	155	180	116,1
Дэлхийн хэмжээгээр	1861	248,6	133,6

Хүснэгтээс үзэхэд 1920—1950 онд Ази тивийн хүн амын тоо 132,9 хувиар өссөн байхад Европ тивийнх 120,6 хувиар, Америкийнх 159,2 хувиар, Африкийнх 151,7 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл Ази тивийн хүн амын өсөлтийн хурдац дэлхийн хүн амын өсөлтийн дундач хурдацаас нэлээд доогуур байлаа. Тухайлбал: 1920—1950 онд дэлхийн хүн амын тоо 1861 саяас 2486 сая болж 625 саяар буюу 133,6 хувиар өссөн нь Азийн хүн амын өсөлтөөс 1,1 пунктээр илүү байна. Ийнхүү XX зууны эхний хагаст Ази тивийн хүн амын тооны өсөлтийн хурдац харьцангуй удаан байхад манай орны хүн амын тооны өсөлт бүр удаан, Азийн хүн амын тооны өсөлтийн дундажаас бараг 2 дахин доогуур байгаа нь уулаасаа цөөхөн хүн амтай Монгол улсын хүн амын тооны өсөлт туйлын удаан бараг зогсонги байдалд байсныг нотлон харуулж байна.

Энэ зууны эхний хагаст ийнхүү манай улсын хүн амын тоо бараг өсөөгүй зогсонги байдалтай байсны шалтгаан нь чухам юунд оршиж байна? Яагаад хүн ам цөөнтэй Монгол улсад дэлхийн бусад оронд гарсан шиг хүн амын зүйн хөгжилт явагдсангүй вэ? Манай орон хүн амаа өсгөх боломжийг яагаад алдав? гэсэн олон асуулт зүй ёсоор тавигдаж байна. Энэ хугацаанд манай улсад халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайн болон хилийн мөргөлдөөнүүд гарч байсан боловч үүнээс үүдэн гарсан хүний хохирол нь харьцангуй цөөн болохоор хүн амын нөхөн үржихүйд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэнгүй билээ. Мөн түүнчлэн энэ хугацаанд Монгол оронд олон арван мянган хүнийг үхэлд хүргэсэн өлсгөлөн, өвчин тахал, байгалийн аюумшигт үзэгдэл гараагүй билээ. Энэ нөхцөлд хүн амын нөхөн үржихүйн процесс маш удаашралтай явагдсан нь ихээхэн сонирхол татаж байгаа болно.

Хүн амын нөхөн үржихүйн процесст дүгнэлт өгөхийн тулд түүнийг бүрдүүлэгч үндсэн үзүүлэлтүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнд задлан шинжилгээ хийх шаардлагатай юм. Хүн амын тооны өсөлтөд түүний нас баралтын төвшин ихээхэн нөлөөлдөг. Тухайн үед Монголын хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажил эхлэлийн төдий байсан, хүмүүсийн соёл, боловсролын төвшин доогуур, нийгмийн олон халдварт өвчин нэлээд хэмжээтэй байсаар байсантай уялдаж одоогийнхтой харьцуулбал нас баралтын төвшин ихээхэн өндөр хэмжээтэй байна.

Хүснэгт 3.

Монгол улсын хүн амын нас баралт⁶
(1935—1940 онуудад) (1000 хүн амд)

он	эрэгтэй	эмэгтэй	бүгд
1935	16,2	16,5	16,3
1936	23,1	23,1	23,1
1937	20,1	19,3	19,7
1938	21,7	18,6	20,1
1939	23,7	23,1	23,4
1940	22,9	20,7	21,8
1935—1940	21,3	20,2	20,7

Хүснэгтээс үзэхэд 1935—1940 онд манай хүн амын нас баралтын төвшин нэлээд хэлбэлзэлтэй дунджаар 20,7 байна. Хүн амын нас баралтын энэхүү тоо нь хэдийгээр одоогийн иргэний гэр бүлийн бүртгэл, Статистикийн мэдээ шиг нарийн биш ч гэсэн ямар нэг хэмжээгээр баримжаа болох зүйл гэдгийг үндэслэж бид дээрх материалд тулгуурласан билээ. Дээрх тооноос үзэхэд тухайн үед эрэгтэйчүүдийн нас баралт нь эмэгтэйчүүдийнхээс их байгаа нь харагдаж байна.

Энэ үзүүлэлтийг 1930-аад оны Азийн бусад орны хүн амын нас баралттай харьцуулж үзвэл ихээхэн доогуур байсан билээ. Тухайлбал: 1000 хүн амд ноогдох нас баралтын төвшин 1937 онд хятадад 25,1⁷ Энэтхэгт 1931—1940 онд 31,2⁸ тус тус байв. Харин японд хүн амын нас баралтын төвшин манайхаас нэлээд бага, 1933—1937 оны байдлаар 17,5 байлаа. Эндээс дүгнэвэл 1920—1950 онд Монгол улсын хүн амын нас баралтын төвшин Азийн бусад орныг бодвол харьцангуй бага хэмжээтэй байсан бөгөөд энэхүү үзүүлэлт манай хүн амын тооны зогсонги байсны үндсэн шалтгаан бус юм.

Хүн амын тооны өсөлт цэвэр өсөлт буюу нас барагдсын тооноос давж гарсан төрөгсдийн тоогоор илэрхийлэгдэнэ. Гэтэл тухайн үеийн Монголын хүн амын нөхөн үржихүйн үзүүлэлтэд анализ хийж үзэхэд төрөлтийн төвшин маш бага зарим тохиолдолд нас баралтынхаа төвшинөөсөө ч доогуур орсон байлаа.

Хүснэгт 4.

Монгол улсын хүн амын төрөлт⁹
(1934—1940 он)

Он	1000 хүн ам дутмын төрөлт	Нас баралтаасаа илүү, дутуу
1934	14,2	
1935	18,5	+2,2
1936	16,5	+7,6
1937	19,0	-0,7
1938	20,7	+0,6
1939	19,1	-4,3
1940	26,1	+4,3
1934—1940	19,1	+1,6

Хүснэгтээс үзвэл 1934—1940 онд манай улсын хүн амын төрөлтийн байдал ихээхэн хэлбэлзэлтэй 1000 хүн ам дутамд 14,2—26,1 байснаас тооцоолж үзвэл дунджаар 19,1 хүн төрж байлаа. Гэтэл энэ хугацаанд хүн амын төрөлтийн төвшин хятадад 1000 хүн амд 35, Японд 30,8, Энэтхэгт 45—48 тус тус байсан¹⁰ бөгөөд Азийн бусад оронд үүнээс ч өндөр байлаа. Ийнхүү хүн амын төрөлтийн үзүүлэлт маш бага, Азийн бусад оронтой харьцуулбал дунджаар 2 илүү дахин доогуур байсан нь уулаасаа хүн ам цөөн Монгол орны хувьд хүн амын өргөтгөсөн нөхөн үржихүй байтугай энгийн нөхөн үржихүйг хангаж чадахгүй зарим жилд хүн амын тоо хорогдох байдалд ч хүргэж байлаа. Энх цагт, тэр тусмаа өлсгөлөн болоогүй, халдварт өвчний тархалт болоогүй үед хүн амын өсөлт зогсонги байдалд орж тэр ч байтугай хорогдсон тохиолдол дэлхийн 2 дайны хооронд өөр улсад тэр тусмаа Европын орнуудад ч гараагүй болно. 1920—1940 онд хүн амын төрөлтийн төвшин Европын ихэнх оронд манай улсынхаас өндөр, 1000 хүн амд 19,5—35 хүртэл байлаа. Зөвхөн Англи, Франц, Швейцар, Швед улсад манайхаас доогуур 1000 хүн амд 14,4—18 байсан юм. Хойд хөрш хуучин ЗХУ-д хүртэл хүн амын төрөлтийн үзүүлэлт ихээхэн өндөр, дээрхи хугацаанд 1000 хүн амд 30—45 байлаа.¹² Үүнээс дүгнэвэл манай хүн амын тоо 1921—1950 онд зогсонги байсны үндсэн шалтгаан нь тус улсын хүн амын төрөлтийн төвшин маш бага байсанд оршиж байна. Эндээс тухайн үеийн Монгол улсын хүн амын төрөлтийн төвшин маш бага, хэтэрхий доогуур байсны шалтгаан юунд орших вэ? гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байгаа билээ.

Хүн амын төрөлтийн төвшин эмэгтэйчүүдийн төрөх чадвараас шууд хамаардаг. Тэгвэл монгол эмэгтэйн төрөх чадвар бусад хөрш зэргэлдээх Азийн орны эмэгтэйчүүдийн төрөх чадвараас муу байснаас болж манай хүн амын төрөлтийн төвшин тийм доогуур байв уу? Үгүй ээ!!! Монгол эмэгтэйчүүдийн төрөх чадвар бусад аль ч үндэстний эмэгтэйчүүдийнхээс доогуур бишийг Монголд олон хүүхэдтэй эхчүүд түүний дотор 10, түүнээс дээш насны хүүхэдтэй эхчүүд цөөнгүй байснаар нотлогдож байна. Мөн түүнчлэн 1950-иад оноос хойш гадаад, дотоодын тохиромжтой нөхцөлөөс уялдан гарсан хүн ам зүйн эрчимтэй хөгжил, Монголын хүн амын түргэн өсөлт (Тухайлбал: 1960 онд хүн амын төрөлтийн төвшин 1000 хүн амд 43,2 хүрсэн явдал)

нотлон харуулж байгаа юм. Нөгөө талаар Монголын аж байдлын онцлог, мах, сүү, цагаан идээ зэрэг илчлэг, аминдэм бүхий зүйлсийг хүнсэндээ голчлон хэрэглэдэгээс хамаарч манай эмэгтэйчүүдийн ерөнхий эрүүл мэндийн байдал хүн ам олонтой суурьшмал улсуудынхаас илүү сайн, чийрэг билээ. Энэ нь тухайн үеийн Монгол оронд орчин цагийн анагаах ухааны ололт дөнгөж нэвтэрч эхэлж байсантай уялдаж хүн амын дотор өвчлөлт, түүний дотор арьс өнгөний өвчнөөр өвдөх явдал харьцангуй их байсныг үгүйсгэж байгаа хэрэг бишээ. Иймэрхүү байдал Хятад, Солонгос, Энэтхэг, Иран, Афганистан зэрэг Азийн улсад төдийгүй хуучин ЗХУ, Польш, Румын зэрэг Европын оронд ч тэр цаг үед мөн адил түгээмэл байсан юм. Ийм ч учраас зөвхөн Монголд төдийгүй бусад оронд 1920—1950-иад онд хүн амын нас баралт түүний дотор нялхсын нас баралт өндөр байсан билээ. Энэ талаар өмнө тодорхой дурьдсан болно. Харин ч Монголд хүн амын эрүүл мэндийг ихээхэн доройтуулж, эмэгтэйчүүдийн төрөх чадварт муугаар нөлөөлдөг хумхаа зэрэг халуун орны олон аймшигт өвчин байдаггүй байсан бөгөөд одоо ч гарахгүй байгаа билээ. Мөн нөгөө талаар манай орны болон гадаадын түүхчид, эдийн засагчдын судалгаа тухайн үеийн Монгол орны хүн амын амьжиргааны төвшин хөрш орнуудынхаас ялангуяа Хятад, Солонгос зэрэг газар тариалан голчлон эрхэлдэг байсан улсын ард түмнийхээс доор байгаагүйгээр барахгүй харин ч ихээхэн дээгүүр байсныг тэмдэглэсэн билээ. Тухайлбал: Оросын эрдэмтэн И. М. Майскийн судалгаагаар энэ зууны эхээр Монголын нэг хүн амын хоногт хэрэглэх хүнсний зүйлийн илчлэгийн хэмжээ 3565,9 кал байсан нь тухайн үеийн Хятад, Солонгос зэрэг Азийн улсын хүн амын хэрэглээнээс өндөр, дэлхийд ч дээгүүр орох үзүүлэлт байлаа. Эндээс дүгнэвэл 1920—1950 оны хооронд манай хүн амын тооны өсөлт зогсонги байж бусад хөрш орныхтой адилхан хүн амаа өсгөх боломжийг алдсаны үндсэн шалтгаан нь Монголын эмэгтэйчүүдийн төрөх чадвар бага, эрүүл мэндийн байдал муу байсанд биш харин хүн амын нөгөө хэсэг болсон эрэгтэйчүүдээс шууд хамаарсан байна. Зөвхөн энэ үед төдийгүй үүнээс өмнөх үед манай хүн амын өсөлт зогсонги түүгээр ч барахгүй хүн амаань улам цөөрөх хандлагатай байсны үндсэн шалтгаан хүн амын нөхөн үржихүйд оролцох Монгол эрчүүдийн оролцоо харьцангуй бага байсанд оршиж байна. Дээрх дүгнэлтээс яагаад хүн амын нөхөн үржихүйд оролцох Монголын эрэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байсан бэ? Манай эрчүүдийн амьдралын чадавхи бусад орны эрчүүдийнхээс доор байсан юм уу гэсэн асуудал мөн л тавигдах болж байна. Гэтэл тийм биш гэдгийг Монголын эмэгтэйчүүдийн төрөх чадварын талаар тавьсан асуултдаа өгсөн өмнөх хариулт давхар нотолж байгаа билээ. Тавиад оноос хойш хүн амын өсөлт түргэссэн нь зөвхөн эмэгтэйчүүдийн үйл ажиллагаатай холбоотой гэдэг нь хэнд ч илэрхий шүү дээ.

Зарим судлаачид ялангуяа гадаадын эрдэмтэд Монголчуудын эрхэлж ирсэн нүүдлийн мал аж ахуй нь газар тариалан түүний дотор усалгаатай газар тариалан шиг хүүхдийн хөдөлмөрийг ихээр шаарддаггүй, иймээс гэр бүл олон хүүхэдтэй байх эдийн засгийн шаардлага бага байснаас Монголын хүн амын өсөлт бага байсан хэмээн үздэг явдал ч бий. Мөн Монголчуудын тооны өсөлт удаан байсныг манай орны эрс тэс уур амьсгалаас шалтгаалан тайлбарлах нь ч бий. Гэвч эдгээрийн аль нь ч үндэстэй бус гэдгийг манайхтай ойролцоо цагаартай, мөн л адилхан бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг байсан лалын шашинтай Казах, Киргиз зэргийн нүүдэлчдийн хүн амын тооны

түргэн өсөлт, Монголын хүн ам зүйн XIII зууны үеийн болон 1950-иад оноос хойшхи эрчимтэй хөгжил нотолж байна. Тэгээд ч манай бэлчээрийн мал аж ахуйд төрөл бүрийн насны хүүхдүүдийн оролцоо үлэмж шаардлагатай, тэдний хийх ажил их байдгийг Монгол хүн бүр мэднэ. Дээрх нь Монголын хүн амын өсөлтийг хязгаарлах уламжлалт мал аж ахуйн тогтолцооноос шалтгаалсан эдний засгийн саад тотгор байгаагүйг харуулж байгаа бөгөөд нөгөө талаар хүн амын өсөлт бага байсан нь хүн амын нөхөн үржихүүд оролцох эрэгтэйчүүдийн оролцоо бага байснаас голлон шалтгаалсан гэсэн өмнөх дүгнэлтийг нотолж байна.

Сүүлийн 200 гаруй жилийн дотор ялангуяа 1920—1950 онд хүн амын нөхөн үржихүүд оролцох Монгол эрэгтэйчүүдийн оролцоо бага байсан нь манай эрэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь хэвийн гэр бүлийн амьдралаар амьдрахгүй байсантай холбоотой. Энэ нь Монгол улсад XVII зуунаас эхлэн манж зэрэг харийн улсын идэвхтэй дэмжлэгтэйгээр шарын шашин хүчтэй нэвтрэн ирж, улмаар оюун санааны амьдралд гол үүрэг гүйцэтгэх болсонтой уялдаатайгаар лам нарын тоо эрс өсөж энэ зууны эхэн гэхэд 118 мянгаад эрчүүд буюу монголын бүх насанд хүрсэн эрэгтэйчүүдийн бага тал хувь нь сүм хийдэд шавилан суух болсноос голлон шалтгаалсан юм.¹⁴ Шарын шашины зан үйл ёсоор лам нар эхнэр авах ёсгүй байсан нь хүн амын өсөлтийг зогсонги байлгах үндсэн нөхцөл болсон юм. Мэргэжилтнүүдийн хийсэн тооцооноос үзэхэд хүн амын төрөлтийн төвшин, лам нарын тооны корреляцийн хамаарал 0,628 байсан нь хүн амын төрөлтийн төвшин бага байсны гол шалтгаан нь эрэгтэйчүүдийн бараг тал хувь нь сүм хийдэд шавилан сууж байсан явдал юм гэдгийг нотлон харуулж байна.¹⁵ Нөхөн үржихүйн насны идэр, залуу эрэгтэйчүүдийн бараг тавин хувь нь урт удаан хугацаагаар, насан туршдаа гэр бүлийн хэвийн амьдралаас хөндий байсан ийм жишээ тайван цагт дэлхийн түүхэнд гарч байгаагүй болно. Бурхны шашны төв гэгддэг Түвдэд ч гэсэн нийт эрэгтэйчүүдийн цөөхөн хувь нь сүм хийдэд шавилан сууж байсан юм. Ийм байдал 1930-аад оны сүүл хүртэл үргэжилсэн болно. Тухайн үеийн төр, засгаас шашин, лам нарын эсрэг хийсэн тэмцлийн үр дүнд 1924—1936 онд лам нарын тоо 112,7 мянгаас 77,7 мянга болон цөөрч, эрэгтэйчүүдийн дотор тэдгээрийн эзлэх хувийн жин 46—20 хувь болтол багассан юм.¹⁶ Ийнхүү сүм хийдэд шавилан сууж байсан олон арван мянган идэр залуу эрчүүд гэр бүлтэй болж, хэвийн байдлаар амьдрах боломж гарч ирж монгол улсын хүн ам тооны хувьд түргэн өсөх үе нээгдсэн юм. Гэвч цаг үе бидэнд мөн л өршөөлгүй хандлаа. 1930-аад оны дунд үеэс дэлхийн Олон улсын ялангуяа зүүн хойт Азийн байдал хүндэрч Япон улс Хятадын ихээхэн нутаг дэвсгэрийг түүний дотор Манжуур, Өвөр Монголын хойт хэсгийг эзэлж БНМАУ-ын хил хязгаарт шууд тулж ирж улмаар Монгол улсыг эзлэн түрэмгийлэх бодлогоо илээр явуулах болж, Хилийн мөргөлдөөн гарсан улмаар Халхын голд зарлаагүй дайныг дэгдээсэн билээ. Энэ бүсэд ялангуяа фашистын Герман ЗХУ-д халдан довтолсноор дэлхийн II дайн шинэ шатанд гарсан нь Монгол улсыг батлан хамгаалах хүчин чадлаа дээшлүүлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авахад хүргэсэн юм. Үүнтэй холбоотойгоор манай улс цэргийн тоогоо нэмэгдүүлж, албан хаах хугацааг нь уртасгах болсон явдал хүн амын нөхөн үржихүүд зохисгүй нөлөө үзүүлж, хүн амын тооны өсөлтийг зогсооход хүргэлээ. Өөрөөр хэлбэл 1930-аад оны дунд хүртэл сүм хийдэд 100-аад мянган лам гэр бүлийн амьдралаас хөндийгээр шавилан сууж байсан бол 30-аад оны сүүл 40-өөд онд мөн

тэр орчим идэр, залуу эрчүүд олон жилээр цэргийн албан хаах болсон юм. Ялгаатай нь гэвэл сүм хийдэд олон арван мянган эрчүүд шавилан сууж байсан нь нийгмийн эрх ашиг, улс, орны хөгжлийн сонирхолтой хослоогүйгээр барахгүй харин ч эсрэг зүйл болсон бол 1930-аад оноос улс орныг батлан хамгаалах талаар авч явуулсан арга хэмжээ нь БНМАУ-ын аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хамгаалахад чиглэсэн зайлшгүй чухал зүйл байсан билээ.

1921—1951 онд Монгол улсын хүн амын тооны өсөлт зогсонги байхад ийм бодит шинж чанартай манай улсын түүхэн хөгжилт, тухайн үеийн гадаад, дотоод хүчин зүйлүүдтэй нөхцөлдсөн ийм хоёр үндсэн шалтгаан голлон нөлөөлсөн юм. Өөрөөр хэлбэл ХХ зууны эхний хагасад Монгол оронд хүн ам зүйн хөгжил явагдаагүй, хүн амын тооны өсөлт зогсонги байсан нь нь манай нөхөн үржихүйн насны идэр, залуу эрчүүдийн бараг тал хувь нь гэр бүлийн амьдралаас хөндий сүм хийдэд шавилан сууж байсан болон цэргийн хуаранд албан хааж байснаас үндсэндээ шалтгаалсан юм хэмээн дүгнэхэд болно.

Үүний хамт Монгол хүн амын өсөлт зогсонги байдалд ороход нэг талаар хувьсгалын эсэргүү хар шар феодал, хятадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчид, хятад, японы тагнуул, туршуулын хорлон сүйтгэх ажиллагаа, нөгөө талаар хувьсгалт хууль ёсыг гажуудуулсны улмаас 1930 хэдэн онд олон хүн алагдсан хэлмэгдсэн нь бага биш сөрөг нөлөө үзүүлсэн юм. Дээр дурьдсан хоёр гол шалтгаан нь цөөхөн хүн амтай Монгол улсын хүн амын нөхөн үржихүйд том цохилт болж манай орны хүн амын өсөлтийг олон жилээр хойш татсан юм. Үүнээс үүссэн хүн ам зүйн долгион олоо хүртэл Монгол улсын хүн амын зүйн хөгжилтөд нөлөө үзүүлсээр байна.

1921—1951 онд дээр дурдсан манай орны түүхэн онцлог, гадаад дотоод байдалтай нөхцөлдсөн бодит ба бодит бус үндсэн шалтгаануудаас болж дэлхийн бусад оронд тухайн үед явагдсан шиг хүн амын зүйн эрчимтэй хөгжилт БНМАУ-д явагдсангүйтэй холбогдож тус улсын хүн амын өсөлт зогсонги байдалд орж, цөөхөн хүн амаа өсгөх түүхэн боломжийг алдлаа. Хэрвээ бид цөөхөн хүн амаа өсгөх түүхэн энэ боломжийг алдаагүй, дээрх хугацаанд Монголын хүн ам тавин хувиар өссөн бол 1921—1951 онд манай хүн амын тоо 324 мянгаар өсөж 1951 онд нэг саяд хүрэх бүрэн боломжтой байлаа. Гэтэл бид энэхүү түүхэн боломжийг алдсанаас болж 1951 онд дөнгөж 772,4 мянган хүнтэй байсан юм. Цаг үе улирч, он жил өнгөрөх тусам хүн ам цөөтэй Монгол улсад маань алдагдсан боломж, эргэн бидэндээ хэзээ ч ирэхгүй, энэ сайхан өргөн уудам нутагтаа хүн болж төрөөгүй хүмүүсийн тоо улам нэмэгдсээр байх болно. Энэ юу гэсэн үг вэ? гэвэл хүн ам зүйн өөрийн агуулга, хүн амын нөхөн үржихүйн дотоод зүй тогтолтой холбоотойгоор түүхэн үед алдагдсан хүн ам зүйн чадавхийг ирээдүй хойт үеэс маань нөхөн үржсэн байдлаар шууд нэхэн авдаг юм. Өөрөөр хэлбэл 1951 онд Монгол улс сая хүнтэй байх ёстой байснаа дөнгөж 772,4 мянган хүнтэй болж нөхөн үржихүйн боломжоосоо 227,6 мян. хүнээр дутуу хүнийг хүлээж авсан болно. Хэрвээ бид ХХ зууны эхний хагасын хүн ам зүйн түүхэн боломжоо алдалгүй 227,6 мянган иргэнээ хүлээж авсан бол одоо эдний үр ач төдийгүй гуч нь төрж энэ нь даруй 1993 оны 1-р сарын 1-ний байдлаар 668 мянган хүн буюу бараг 700 мянган хүн болох юм. Ингэсэн бол Монгол улс одоо 2,2 сая биш 3,0 сая шахам хүн амтай байх байлаа. Үүнтэй холбогдуулж хэлэхэд би энэ өгүүллийнхээ дунд дурьдсанчлан Монгол улс дэлхийн бусад орон шиг XIX зуунд хүн амаа 2—3 дахин өсгөж энэ зууныг 2 сая хүн амтайгаар угтсан бол одоо манай улсын хүн ам 5 сая 800 мянга буюу бараг 6 сая хүрэх

байсан юм. Өргөн уудам нутагтай, байгалийн асар их баялагтай Монгол улсын био-уур амьсгалын нөөц нь одоогийн шинжлэх ухаан техникийн хөгжлийн төвшинд доод тал нь 10 сая хүнийг тэжээж, амьдруулах бүрэн боломжтой гэдгийг манай газарзүйчид, биологичид, олонтоо нотлон бичсэн билээ. Монгол улсын хөдөө аж ахуйн эдэлбэр газар одоогийн байдлаар 126,1 сая га байгаа нь нэг хүнд 57,3 га газар ногдож байна гэсэн үг юм¹⁷ Үүний 90 гаруй хувь буюу 120 сая гаруй га нь малын бэлчээр болно. Эрдэмтдийн тооцоолсноор манай еронд тариаланд тохиромжтой талбай 3 сая га-г илрүүлсний 1,3 сая га нь эргэлтэнд байгаа билээ. Энэхүү тариаланд тохиромжтой 3 сая га талбайн зөвхөн 2 сая га-г нь тариалаад, га-талбайгаас дэлхийн хөгжилтэй орнууд шиг 50—60 цент. түүнээс илүү ургац авахгүй хамгийн багад тооцогдох ердөө л 20 цент. ургац авъя гэж үзвэл бид жилд дунджаар 4 са я. тн үр тариа хураан авах болно. Ийм хэмжээний ургац авах бүрэн боломжтой болохыг өнгөрсөн жил Булганы Ингэт-толгой болон бусад аж ахуй (хуучнаар нь бичлээ) нэг га-гаас энэ хэмжээний, үүнээс илүү ургац авсан явдал баталж байна. 4 сая. тн үр тариа нь 10 сая хүнийг талх, тарнагаар хангаад зогсохгүй, гадаадад нэлээд хэмжээгээр гаргахад элбэг хүрэлцэх болно.

Манай улс өөрчлөлт шинэчлэлтийн энэ эрин үед одоогийнх шигээ дөнгөж 2,2 сая хүн амтай биш, харин 6,0 сая хүнтэй байсан бол Монгол улсын орчин цагийн нийгмийн хөгжилт, эдийн засгийн хүчин чадал, үр нөлөө, олон улсын тавцанд эзлэх байр суурь ямар хэмжээнд байх нь ойлгомжтой. Үүнтэй холбогдуулаад хэлэхэд шарын шашны болон бусад дээр дурьдсан шалтгааны улмаас алдагдсан хүн ам зүйн хохирол зөвхөн Монгол улсын нутгаар ч биш бусад Монгол туургатныг ч нэгмөсөн хамарсан билээ.

Түүх Монголчууд бидэнд хатуу ширүүн хандсан юм. Дэлхийн бусад угсаатан шиг хүн амын тоогоо олон дахин өсгөх сайхан бололцоог хэрэгжүүлэх боломжийг олгоогүй. Чухамхүү үүнээсээ ч шалтгаалж ХХI зууныг Монголчууд бид хамгийн цөөн тоотой угсаатнуудын, манай Монгол улс хамгийн цөөн хүн амтай улсуудын тоонд орж алхах болж байна. Энэ бол бодит байдал. Гэвч хэдий цөөн тоотой ч гэсэн буурал түүхийн мянга, мянган жилд өөрийн үндэс, угсаагаа хадгалан ирсэн төдийгүй туурга тусгаар, бүрэн эрхт Монгол улсаа бидэнд хүлээлгэн өгсөн саруул ухаант, эрэлхэг зоригт өвөг, дээдэстээ бид баярлаж, тэдний бидэнд өвлүүлж өгсөн Монгол улсаа цэцэглүүлэн хөгжүүлэхийн төлөө бүхнийг хийх хэрэгтэй.

Энэ өгүүлэлдээ би манай Монголчуудын санааг эрт дээр үеэс зовоож, хамгийн их эмзэглүүлж байсан асуудлыг хөндлөө. Түүх бол түүх. Хичнээн харамсалтай ч, хэдий хүсэвч, Монгол улсын хүн ам маань дээр дурьдсанчлан 3 сая, 6 сая биш, дөнгөж 2,2 сая. Бид үүнтэйгээ эвлэрэхээс өөр аргагүй. Түүх гэдэг бол агуу их багш. Хувь хүн, хүмүүс, ард түмэн түүхээсээ суралцаж, гаргасан алдаагаа давтчихгүйн тулд бүхнийг хийх ёстой. Хорьдугаар зууны эцсийн орчин үеийн Монгол улс хүн ам зүйн эрчимтэй хөгжлийн шатан дээр байна. Сүүлийн 800 жилд анх удаа бодит байдал болсон энэ сайхан боломж дэлхий ертөнцөд их өөрчлөлт гарч, манай улсын дотоод байдал, нийгэм-эдийн засгийн хөгжилтөд шинэ нөхцөл байдлыг авчирсан 1950-иад оноос эхэлсэн билээ. Үүний үр дүнд 1950 оны эхнээс манай улсын хүн амын төрөлтийн төвшин дээшилж 1960-аад оны дунд үед дээд хэмжээнд хүрч, тогтворжсон юм. Энэ нь хүн амын нас барилттай хосолж хүн амын тооны өсөлтийн хурдацыг түргэтгэх бололцоог олгосон юм. Ийнхүү сүүлийн дөчин жилд манай улсын хүн

амын тоо түргэн хурдацтай нэмэгдэж, энэ хугацаанд 2,9 дахин өсөж 2 саяд хүрлээ. Энэ явдлыг Монголын ард түмний XX зууны II хагаст олсон хамгийн том ололт хэмээн үзвэл зохино. Цөөхөн хүн амаа өсгөх түүхэн энэ боломжийг аль болох удаан хугацаанд тогтоож, дээд зэргээр ашиглах нь бидний тэргүүн зэргийн зорилт байх ёстой. Энэ түүхэнб оломжийг алдвал бид цөөхөн Монголчуудаа олшруулах талаар эцэс сүүлд нь хичнээн их хөрөнгө гаргаад ч, хичнээн их хүч зараад ч ашиггүй байх болно. Үүнийг хүн ам зүйн хөгжлийн эрчимтэй үе нь нэгэнт дууссан, одоо хүн амын тоо нь хорогдох процесс (депопуляци) явагдаж буй ХБНГУ, Англи, Бельги зэрэг Баруун Европын өндөр хөгжилтэй орны гашуун туршлага харуулж байна. Монголын хүн ам зүйн эрчимтэй хөгжлийн энэ түүхэн үе нь өөрийн зүй тогтлоороо явбал манай хүн ам зүйчдийн үзэж байгаагаар 2020 он хүртэл, НҮБ-ын мэргэжилтнүүдийн үнэлэлтээр 2040 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байгаа юм.¹⁸

Гэвч 1989 оны эцсээс зарим удирдах хүмүүс өргөн уудам нутагтай, байгалийн асар их баялагтай боловч хүн ам цөөнтэй манай орны онцлог, монголын хүн ам зүйн өвөрмөц, давтагдашгүй нөхцөл байдлыг үл ойшоон, харгалзан үзэхгүйгээр өөрийн яам, байгууллагын явцуу сонирхол, хувийн албан тушаалын ганц талын эрх ашгийг урьтал болгон, хүнээ багтааж ядсан, хамгийн олон хүн амтай Хятад зэрэг орны хүн ам зүйн бодлогыг үнэн чанартаа шууд хуулбарласан бодлогыг «Гэр бүл төлөвлөлт» хэмээх нэрийн дор элдэв сайхан үгээр халхавчлан явуулах болсон юм. Энэ дагуу БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 12-р сарын 200-р зарлигаар эмэгтэйчүүдийн үр хөндөх явдлыг чөлөөтэй болгож, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, тохирох, тохирохгүй элдэв хэрэгслэлийг задгай тавьж, эмэгтэйчүүдийг цөөхөн төрөхийг сурталчилсан сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр өргөнөөр хийх боллоо. Хүн ам цөөтэй, хүмүүсийн ихэнх нь хот суурин газарт суудаг, эмэгтэйчүүдийн боловсролын төвшин өндөр, олонхи нь улс, хоршооллын байгууллагуудад хөдөлмөр эрхэлдэг манай улсын нөхцөлд хүн ам зүйн ийм бодлогыг хэрэгжүүлэх нь туйлын хүнд уршигтай, эцэстээ Монгол улсын тусгаар тогтнолыг алдагдуулж, Монгол үндэстнийг мөхөлд хүргэж ч мэдэх их аюултай зүйл гэдгийг ойлгох цаг болжээ. Энэ хүн ам зүйн бодлогын буруу болох нь одоо ч амьдралаар нотлогдож байна. Тухайлбал: тус улсын хүн амын төрөлтийн төвшин 1970-аад оноос хойш буурч ирсэн боловч хүн амын тоо өсөж буйтай холбоотойгоор төрсөн эмэгтэйчүүдийн тоо 1950 оноос хойш жил дараалан өсөж ирсэн юм. Үүний дотор 1989 он гэхэд л төрсөн хүүхдийн тоо өмнөх 1988 оныхоос 3 мянгаар өссөн билээ. Гэтэл «Гэр бүл төлөвлөлтийн бодлого» нэрийн дор дээр дурдсан «шинэлэг» арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн 1990 онд сүүлийн 40 жилд нэмэгдэж байсан төрсөн хүүхдийн тоо анх удаа буурч, төрөлт өмнөх 1989 оныхоосоо 3,2 мянган хүнээр цөөрөв. Төрөлтийн тооны энэхүү бууралт 1991 онд улам нэмэгдэж 3,9 мянга боллоо. 1992 онд төрөлтийн уналт улам түргэсэж өмнөх оныхоосоо төрсөн эмэгтэйчүүдийн тоо 7,4 мянгаар хорогджээ.

Хүснэгт 5.

Монгол улсын хүн амын төрөл, 1951—1992
онд (мян. хүнээр)

Он	Төрөлт
1951	16,8
1955	26,8
1960	40,7

1965	50,8
1970	55,2
1975	59,7
1980	63,7
1985	70,1
1989	78,0
1990	74,8
1991	70,9
1992	63,5

Хүснэгтээс үзэхэд 1989 онд 78,0 мянган хүүхэд төрж байсан бол 1992 онд 63,5 мян. хүүхэд төрөх болж төрөлтийн тоо гуравхан жилийн дотор 14,5 мянгаар цөөрч 1980 оныхоо байдалд буцаж орлоо. Энэ манай нөхцөлд үл тохирох хүн ам зүйн бодлогыг хэрэгжүүлээд байвал төрөлтийн уналт улам гүнзгийрч, Монгол улсын хүн амын өсөлт XXI зууны эхээр зогсонги байдалд орж цаашдаа хүн амын тоо хорогдох байдалд ч хүрэх болно. Манай хүн ам зүйчдийн тооцоогоор Монгол улсын хүн амын нөхөн үржихүйн процесс 2020 он гэхэд 4 сая болж цаашдаа 5 саяд хүрч тогтворжих төлөвтэй байгаа билээ. Хэрэв бид одоогийнх шигээ сайхан үгээр халхавчилж энэ дэлхийн хамгийн олон хүн амтай улсын хүн ам зүйн бодлогыг үнэн чанартаа хуулбарлан хэрэглээд байвал 2020 онд Монгол улсын хүн ам 4 саяд хүрэх байтугай одоогийнхоосоо хорогдож 2 сая хүрэхгүй байдалд орж болзошгүй байна. Монгол улс бол Хятад биш, Энэтхэг биш, Бангладеш Пакистан, Индонез биш, Монголчууд бол хань, ханди, Бенгал, малайчууд биш.

Цөөхөн хүн амаа өсгөхийн тулд Монгол улсынхаа өвөрмөц, онцлог байдалд тохирсон өөрийн хүн ам зүйн бодлогыг хэрэгжүүлэх талаар тууштай ажиллах хэрэгтэй байна. Бусдын туршлагыг тэр тусмаа манай оронд огт тохирохгүй бодлогыг хуулбарлан хэрэгжүүлэх нь ямар байдалд хүргэдгийг Монгол улсын сүүлийн 70 жилийн замнал, туршлага нотлон харуулж байна. Түүхээсээ сургамж авцгаая. Түүхээс бидэнд олгогдоод байгаа цөөхөн хүн амаа өсгөх энэ боломжийг бүрэн дүүрэн ашиглая.

1. В. В. Петров. Народонаселение Индии Москва. 1978. 22-р талд.
2. «Үнэн» 1966. 12. 30.
3. Население мира М. 1965, 1989 Население земного Шара М. 1965. Народонаселение стран мира М. 1984; Демографический энциклопедический словарь. М. 1985., зэргийг ашиглаж тооцов. (Н. Б)
4. В. Urlanis. Wars and population, М. 1971, р 294
5. Естественные движение населения Современного мира. М., 1971. 6-р талд.
6. БНМАУ-ын хүн ам. УБ., 1958, 34-р талд.
7. Население мира. М., 1965, 27-р талд.
8. Население мира. М. 1965, 30-р талд.
9. БНМАУ-ын Хүн ам. УБ., 1968, 30-р талд.
10. Население мира. М. 1965.
11. Насеелние мира. М. 1965. 24—25-р талд.
12. Мөн ном 15-р талд.
13. И. М. Майский. Монголия накануне революции. М. 1959.
14. Б. Гунгаадаш, Р. Гүр. БНМАУ-ын хүн ам. 1968, 26-р талд.
15. Д. Мягмар. БНМАУ-ын хөдөлмөрийн нөөц, түүний ашиглалтыг сайжруулах асуудал. УБ., 1972, 18-р талд.
16. Б. Гунгаадаш, Р. Гүр. БНМАУ-ын хүн ам. УБ., 1968, 26-р тал.
17. Монголын эдийн засаг, нийгэм 1991 онд. УБ., 1992 он, 51-р талд.
18. World population prospects, 1990. New York, 1991 p. 46